 (тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)

Тусгай зөвшөөрөлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд

№/№	Солбицлууд өөрчлөгдөх үзүүслэл	Хүчин тогтолцор солбицлууд																																			
1.	Талбайн солбицлууд	<table> <thead> <tr> <th>No</th> <th>град</th> <th>мин</th> <th>сек</th> <th>град</th> <th>мин</th> <th>сек</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>106</td> <td>3</td> <td>15</td> <td>49</td> <td>26</td> <td>10</td> </tr> <tr> <td>2</td> <td>106</td> <td>3</td> <td>15</td> <td>49</td> <td>26</td> <td>26</td> </tr> <tr> <td>3</td> <td>106</td> <td>3</td> <td>40</td> <td>49</td> <td>26</td> <td>26</td> </tr> <tr> <td>4</td> <td>106</td> <td>3</td> <td>40</td> <td>49</td> <td>26</td> <td>10</td> </tr> </tbody> </table> <p>2009-06-23</p>	No	град	мин	сек	град	мин	сек	1	106	3	15	49	26	10	2	106	3	15	49	26	26	3	106	3	40	49	26	26	4	106	3	40	49	26	10
No	град	мин	сек	град	мин	сек																															
1	106	3	15	49	26	10																															
2	106	3	15	49	26	26																															
3	106	3	40	49	26	26																															
4	106	3	40	49	26	10																															
2.	Тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөрөө төвлөв.	<p>Тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөрөө төвлөв.</p> <p>2010-03-31</p>																																			




8!

ЦОГТ-4350Х тоот тусгай
зөвшөөрөл буйд талбайн
байраулын зураг

Сэргийн тогтолцоо: Улаан хордигийн тогтолцоо
Өндүйн тогтолцоо: Багийн тогтолцоо тогтолцоо


Дархан Уул Аймаг,
Хонгор сум, Бурзинт хондий



Д.Баттоо
Ч.Төмөржүх

Масштаб 1:2000
1 см = 20 м бетсэн.
Төлийн энэдр 1 м.

Бүрзинт 2008 оны 1-р сард
ЗА ХС СИ Ихчилнэрийн ХКБ-д үзүүрээр



"СИЛИКАТ" ХХ-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 01

Дархан Уул аймаг


Хувьцаа хуваах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 52, 63-р зүйл, компанийн дурмийн 6-р зүйл, "Сүлд Аудит" ХХК-ийн аудиталсан 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан эзэмшигчийн өмчийн дүн болон Хувь нийлүүлэгчдийн зэлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани нь өөрийн хувьцааны зах зээл дэх эргэлтийг идэвхижүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зорилгоор нэгж хувьцааг 177 ширхэгт хуваасугай.
2. Хувьцаа хуваагдсаны дараа компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 (гучин сая нэг зуун авсан хоёр гурван зуун хоёр) ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. Хувьцаа хуваагдан компанийн нийт хувьцаанд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэн, бүртгүүлэхийг гүйцэтгэх захидал Ц.Содбилэгт үүрэг болгосугай.

Хувьцаа хуваах тухай асуудал нь хувь нийлүүлэгчдийн 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурал, 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн төвлөвлөн удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэгдэн холбогдох шийдвэрүүд гарч байсан болно.

ХУРЛЫН ДАРГА: Ж.ГАНБОЛД



"СИЛИКАТ" ХХ-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011/05/01

№ 02

Дархан Уул аймаг

Нэмэлт хувьцаа гаргах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 34, 39, 63-р зүйл, Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ Нь:

1. Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өр төлберийн асуудлыг шийдвэрлэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 (арван зургаан сая хоёр зуун хорин хоёр турван зуу) ширхэг хувьцааг зах зээлд санал болгон хөрөнгө татаан төвлөрүүлсүгэй.
2. Нэмж гаргаж буй хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн тэргүүн эзлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй, олон нийтэд адил эрхтэйгээр зах зээлд санал болгосугай.
3. Нэмж хувьцаа гаргасны дараа компани нь нийт 46 334 602 (дөчин зургаан сая турван зуун гучин дерев зургаан зуун хоёр) ширхэг хувьцаатай байхаар тогтох компанийн дүрмийн заалтад өөрчлөлт оруулсугай.
4. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, зуучлагчтай гэрээ байгуулан олон нийтэд санал болгон хөрөнгө татаан төвлөрүүлж, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахыг гүйцэтгэх захидал Ц.Содбилэгт үүрэг болгосугай.

Нэмж хувьцаа гаргах тухай асуудал нь хувь нийлүүлэгчдийн 2008 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурал, 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн төвлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэзэлцээдэн тоотоол шийдвэрүүд гарч байсан болно.

ХУРЛЫН ДАРГА:*H. Bayz*.....

Ж ГАНБОЛД





СИЛИКАТ ХК
Дархан хот, Улаанбаатарийн дүүргээ,
Силикат компанийн байр,

Хөгжлийн бетон шохогын үйлдвэр

"СИЛИКАТ" ХК-ийн хувь нийтийн тогтолцоогоо

20 .. он .. -р сарын .. .

№ —————

2011/05/01

№ 03

Дархан Уул аймаг

Зах зээлд санал болгох үнэ тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйл, хувь нийтийн тогтолцоогоо

хурлын тооллогын комиссын дүнг удээслэн ТОГТООХ Нь:

1. Нэмж гаргаж буй хувьцааг зах зээрд санал болгох доод үнүүг 225 төгрөөнөөр тогтоосугай.



ХУРЛЫН ДАРГА..... Ж.ГАНБОЛД



Угад/Факс: 976 1372024755, И-майл: info@silikat.mn



СИЛИКАТ ХК

Дарсан хот, Уланбаатарын Дүүрэг.
Санжигт компанийн байр.

ХЕНГЕН БЕТОН ШОХОЙ ҮЗЛЭЛЭР
БИНСЕТУӨВ

"СИЛИКАТ" ХК-ийн хувь нийтийн тогтолцоол

2011/05/01

№ 04

Дархан Улт аймаг


Дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17, 63 дугаар зүйл, хувь нийтийн тогтолцоолын эзжигт бус хурлын тооллогын комиссын дүнг индээслэн ТОГТООН №:

1. Компанийн дүрэмд нэмжтөөрчлөт оруулсан шинэчилсэн найруулга бүхий дүрмийн хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн дүрэмд нэмэгжтөөрчлөт оруулсан шинэчилсэн найруулга бүхий гүйцэтгэх захирагдлыг худалдаанд, багтаван улсын бүртэлд бүртгүүлэхийг
3. Шинэчилсэн найруулга бүхий дүрмийг улсын бүртэлд бүртгүүлсэн өдрөөс 2005 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Хувь нийтийн тогтолцоолын хурлаар батлагдсан компанийн дүрмийг хүчинтүй болсонд тооцугай.

Компанийн дүрэмд вериталт оруулсан тухай түүхийг хувь нийтийн тогтолцоолын 2008 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурлын замгатах асуудалт орж шийдвэрлэсээж байсан болно.

ХУРЛЫН ДАРГА: Ж. ГАНБОЛД



Утас/Факс: 976 1372024755, И-мэйл: info@silikat.mn

Хувь нийтуулэгчдийн 2010 оны 05 сарын 01-ны
өдрийн хурлын 04 тоот тогтоолоор батлав

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "СИЛИКАТ"
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
/Шинэчилсэн найруулга/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ

1.1. "Силикат" ХК нь /цаашид "компани" гэх/ Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулгасан, бие даасан тайлан тэнцэлтэй, Банкны харилцах данстай, эзэмшиж, ашиглах, захирсан зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх здэлж, үүрэг хулээдэг, үйл ажиллагаанаасаас үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн нарийн өмнөөс оропцдог хуулийн этгээд байх бөгөөд хувь нийтуулэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж хувьцаа нь нийтэд арилжаалагддаг /нээлттэй/ компани байна.

1.2. Оноосон наар: Үйлдвэрлэл Худалдааны "Силикат" ХК байна.

1.3. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

1.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу тусгай зөвшөөрөл авч бүртгэлийн байгууллагад бүртгүүлсний дараа үйл ажиллагаагаа явуулна.

1.5. Компани нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч охин болон хараат компани, салбар, төлөөлгөжин газар байгуулж болно.

1.6. Компанийн оршин байгаа хаяг: Монгол Улс, Дархан-Уул аймаг Дархан сум 16 баг болно.

Шудандийн хаяг: Дархан-Уул аймаг Дархан сум "Силикат" ХК. Харилцах утас: 976-1372-24755 Факс: 976-1372-24755

ХОЁР. КОМПАНИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛГААНЫ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1. Компани нь дараах зорилгыг ханган ажиллана:

2.1.1. Хэрэглэгчийнхээ зэрлэгт хэрэгцээнд бүрэн нийцсэн чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх;

2.1.2. Үйлдвэрлэлийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогoo арвижуулж, хувьцааны үнэлээмжийг дээшлүүлэх;

2.1.3. Үйлдвэрлэлийг байгаль орчинд серег нөлөө үзүүлэхгүйгээр зохион байгуулж экологийн тэнцвэрийг бүрэн хадгалж ажиллах;

2.1.4. Улс орны эрх ашиг болон хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчийнхээ эрх ашигийг хамгаалах, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн илүү их ашиг хуваарилах зэрэг болно.

2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

2.2.1. стандарт чанарын шаардлага хангасан царуул тоосго үйлдвэрлэл;

2.2.2. технологийн болон барилгын шохойн үйлдвэрлэл;

2.2.3. сийрмаг царуул бетон эдлэлийн үйлдвэрлэл;



2.2.4. авто замын эрдэс нунтагийн үйлдвэрлэл;

2.2.5. барилын материалын үйлдвэрлэл;

2.2.6. гадаад, дотоод худалдаа;

2.2.7. компанийн техник технологи, тоног төхөөрөмжийг шинэчлэн, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг импортоор авах, тээврийн зардлыг багасгах, үр ашиг, үйлдвэрлэлийн бутээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагатай хамтарсан үйл ажиллагаа явуулах;

2.2.8. дээрх үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бусад бүх үйл ажиллагаа явуулах болно.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Компани нь гадаад, дотоодын байгууллага аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаагаа өргөтгөх хамtran ажиллах, мэргэжилтэн солилцох, хамтарсан үйлдвэрлэл эрхлэх, зуучлал зэрэг хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл бизнес төлөвлөлт нь ТУЗ-ийн удирдлагын хяналтан дор өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

3.3. Компани нь өөрийн нэрийн барааны тэмдэг, эмблем, бэлзг тэмдэгтэй албан бичгийн хэвлэлээр хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэн. Бэлэгдэл, барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлж тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани здлэнэ.

3.4. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл дотоод, гадаадын хуулийн этгээдтэй хамtran Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

3.5. Үйл ажиллагаагаа өргөтгөх зах зээлд ойртох зорилгоор гадаад, дотоодод салбар төлөөлгөгчийн газрыг ажиллуулна.


3.6. Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээгээ хэвийн явуулах зорилгоор мэргэжилдээ чадвар туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн хуулинд нийцүүлэн гэрээгээр авч ажиллуулан тэдний цалин урамшил, ажиллах нөхцлийг нь тогтооно.

3.7. Компани нь өөрийн бизнес үйл ажиллагаатайгаа холбоотой зүйлийг хуулийн дагуу нууцлаж болно.

3.8. Компани нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахтай холбогдуулан сан байгуулж болно.

3.9. Компани нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон анхуу дүрмийн хүрээнд явуулна.

3.10. Компани нь Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.



ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

- 4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнз.
- 4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнз.
- 4.3. Компанийн ТҮЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, дэд захирал, хэлтэс, тасгийн дарга нар гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанийд учруулсан хохирлыг хариуцна.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтанд МУ-ын Компанийн тухай хуулийн 81, 82 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэн.


ТАВ. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1. Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч зэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.
- 5.2. Компанийн хувь нийлүүлэгч нь гэрээ, дүрмийн заалтыг хэлбэрэлтгүй сахиж, компанийн ууцад хамааралтай бүх л зүйлийг чандлан хадгалах, хөдөлмөрийн гарээгээр ажиллах байгаа бол гарээгээр хүлээсэн үүрэг, хөдөлмөрийн хуулийг чанд биелүүлэх, компанийн үнэт цаас зэмшиж байгаа этгээд нь өөрийн нэр, оршин сугаа газрын хаяг болон өөрийн зэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтөлж этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнз.
- 5.3. Хувь нийлүүлэгч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 5.4. ТҮЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед зэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандaa олгохгүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.
- 5.5. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэл эрхтэй.
- 5.6. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн эзлжинд худалдан авах эрхтэй.
- 5.7. Дор дурьдсан асуудлаар гаргасан хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн зэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй:

5.7.1. нийлэх, нэгдэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлен байгуулах болсон бол;

5.7.2. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийтиг дүгнин -25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах,

РХБ-ийн гишүүд
Андерстонтер
Брокер и Ко
БИИН ЦС



худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрөхүүнэтцаас гаргасан зэрэгээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;

5.7.3. компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дурэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;

5.8. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшик байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчдийг компанийн хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

5.9. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь эзлжит хурал хураалдахаас ажлын 45 ба түнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

ЗУРГАА. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, БУСАД ҮНЭТ ЦААС, ТҮҮНИЙ ГАРГАХ, ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

6.1. Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 46 334 602 ширхэг энгийн хувьцаатай 4 633 460 200 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

6.2. Компанийн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтвөх, шинчилэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэн.

6.2.1. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

6.2.2. Компанийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн санд оруулсан хөрөнгийн бүртгэл, жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бур оруулж байна.

6.2.3. Үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөд хөрөнгийн үнэлгээний компанийн тайланг хавсаргаж баталгаажуулна.

6.2.4. Компани нь энгийн болон давуу эрхийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.

6.2.5. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо, нарласэн үнэ, үнийн дүн, үнэт цаас гаргаж төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт, үнэт цаасыг нийтэд, эсхүл хаалттай захиалгаар худалдах, энгийн хувьцаанаас бусад үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрөх эсэх, хөрөх бол хөрөх нөхцөл зэргийг заасан байна.

6.2.6. Нэмж гаргасан энгийн хувьцааг нээлттэй, хаалттай захиалгын аль хэлбэрээр худалдахаар шийдвэрлэснээс үл хамаарч Санхүүгийн зохицуулах хорооны батласан журмын дагуу үнэт цаасыг бүртгүүлэх, андеррайтер болон



зүүчлах үнэт цаасны компанийтай гэрээ байгуулах ажлыг түйцэтгэх захидал хариуцан зохион байгуулна.

6.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3 жил хүртэл хугацаатай ерийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэн. Шийдвэрт ерийн бичиг гаргах болсон үндэслэл, шалтгаан гаргах ерийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хуу төлөх хугацаа, нехцөл, эргэн төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3-аас дээш жилийн хугацаатай ерийн бичиг гаргах асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэн. Шийдвэрт энэ дурмийн 6.3-т заасан зүйлийг мен адил тусгана. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдаж авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдан авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэн. Шийдвэрт опцион гаргах болсон үндэслэл, гаргах опционы тоо, опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдан авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.

6.3.2. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт гаргасан хувьцааны тооноос илүүгүй байна.

6.3.3. Хувьцаа, бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйл заасны дагуу ТУЗ тогтооно.

6.3.4. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийт бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон иоуны өмчийг үнзлэх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнзлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхж бус ТУЗ-ийн гишүүдийн саналаар тогтооно. Үнзлгээг тогтооходоо мэргэжлийн үнзлэгэний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэл болгоно.

6.3.5. ТУЗ-ийн шийдвэрээр компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцхын үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бухэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.

6.4. Компанийн тухай хуулийн 50.8.1, 50.8.2-т зааснаас бусад тохиолдолд компанийн өөрийн гаргасан энгийн хувьцааны 5,0-аас дээш хувийт худалдан авах шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэн. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрт худалдан авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ төлбөрийт хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

6.5. Компани дараах нехцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргах болно.

6.5.1. Хуульд заасан үргүйнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;

6.5.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;



6.5.3. компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнз зэргийн нийлбэрээс их бол.

ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна.

7.2. Хувь нийлүүлэгчдийн хурал нь эзлжит ба эзлжит бус байна.

7.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь "Хувь нийлүүлэгчдийн хурал зарлан хуралдуулах журам"-ыг батлах мөрдүүлнэ.

7.4. Хувь нийлүүлэгчдийн хурал нь компанийн санхүүгийн жил дууссанас хойш жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор ТҮЗ-өөс зарлах бөгөөд компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.

7.5. Хувь нийлүүлэгчдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга удирдан явуулна.

7.6. Хувь нийлүүлэгчдийн хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТҮЗ-ийн гишүүдийг сонгож компанийн тухай хуулийн 71.3, 72.1.3, 72.2, 77.4-т заасны дагуу санал хураалтыг кумулятив аргаар явуулна. Бусад асуудлаар санал хураалтыг явулаахдаа ердийн аргаар санал хураалтыг явуулна.

7.7. Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхийн санаалаар шийдвэрлэнз.

7.8. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны хорооноос баталсан журмын дагуу явуулна.



7.9. Хувь нийлүүлэгч нь компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувь нийлүүлэгчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.

7.10. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонх хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчдид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуулах өдрийг товлож энз тухай тэмдэглэл үйлдэж ТҮЗ-ийн дарга, тэмдэглэл хөтөлгөг гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.

7.11. Саналын эрхийн 60-аас дээш хувь хуралд оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

7.12. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдөр өөрчлөгдхөгүй. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дунд тооцно.

7.13. Компани нь хувь нийлүүлэгчид хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйээр хувь нийлүүлэгчдээс энээс санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Энээс санал хураалтыг Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна. Хувь нийлүүлэгчдийн эзлжит хурлыг



Энэ санал хураалтаар явуулж болохгүй. Энэ санал хураалт явуулахдаа санал хураах худсыг ашиглана.

7.14. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувь нийлүүлэгч нь өөрөө энэ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комиссын ўл ажиллагаанд ажиглагчаар оролцож болно.

7.15. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувь нийлүүлэгчдийн хурлын дараа баталгаажуулан гарын үсэг зурна.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

8.1. Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь компанийн тухай хууль, энэ дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсанасаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.1.1. компанийн ўл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

8.1.2. хувь нийлүүлэгчдийн эзлжит болон эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;

8.1.3. компанийн тухай хууль болон хувь нийлүүлэгчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

8.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүдтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувь нийлүүлэгчдийн эзлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг сонгоходо компанийн тухай хуулийн 77.4, энэ дүрмийн 7.5-д заасан кумулятивт аргыг хэрэглэнэ.

8.3. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ билеүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-еес түүний оронд өөр хүнийг түр томилно.

8.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн үүрэг гүйцэтгэнэ. ТУЗ-ийн дарга нь:


8.4.1. ТУЗ-ийн ўл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүрэгтэй;

8.4.2. өөрийн эрх хэмжээнийгээ хүрээнд компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх, компанийн нэрийн өмнөөс итгэмжлэгүйгээр ўл ажиллагааг явуулах эрхтэй байна.

8.5. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. Төлөөлөн удирдах зөвлөл ўл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.

8.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хучин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.7. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.



ЕС. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

9.1. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрэнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

9.2. Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүн байж болно.

9.3. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрэнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

9.4. Гүйцэтгэх удирдлага нь өөрөө хүсвэл багийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд ийм тохиолдолд ТУЗ-тай зөвшилцсөний үндсэн дээр дотоод журам батлан мөрдөж ажиллана.

9.5. ТУЗ-өөс Гүйцэтгэх захирлын бурэн эрхийг зогсоох, хязгаарлах шийдвэрийг хэзээ ч гаргаж болно.

АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

10.1. Компани санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайлан хувьцаа зээмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

10.2. Компанийн санхүүгийн жил нь жил бурийн 01-р сарын 01-ээс эхэлж 12-р сарын 31-нд дуусгавар болно.

10.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна.

10.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.


10.5. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа зээмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах "бүртгэлийн өдөр" болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа зээмшигчдэд мэдэгдэнэ.

10.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

10.7. Монголын Компанийн Засаглалын кодексын 8 дугаар зүйлийн 8.1.1-т зааснаар "Ногдол ашигийг бодлого"-ыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс боловсруулж Хувь нийлүүлэгчдийн хурлаар батална.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

11.1. Хянан шалгах зөвлөл нь компанийн дүрэм, Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.



11.2. Хувь нийлүүлэгчдийн хурлын олонхийн саналаар хянан шалгах зөвлөлийг З гишүүний бүрэлдэхүүнтэйгээр З жилийн хугацаатай сонгоно

11.3. Хянан шалгах зөвлөл нь жилд 2-оос доошгүй удаа хуралдах ба хурлыг зохион байгуулах, удирдах үүргийг гишүүдээс сонгогдсон хянан шалгах зөвлөлийн дарга гүйцэтгэнэ.

11.4. Дор дурьдсан этгээдийг хянан шалгах зөвлөлийн гишүүн байхыг хориглоно. Үүнд:

11.4.1. эрх зүйн чадамжгүй этгээд бол;

11.4.2. урьд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан бол;

11.4.3. компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой бол;

11.4.4. толгой компани болон охин, хараат, салбар компанид ажилладаг бол;

11.4.5. урьд нь албан тушаал, авилга, хээл хахуулын хэрэгт шийтгэгдэж байсан бол;

11.4.6. Компанийн хувьцааны 5-аас дээш хувь эзэмшдэг болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд бол.

11.5. Хянан шалгах зөвлөл нь хувь нийлүүлэгчдийн хуралд ажлаа тайлгагнаа.

11.6. Монголын Компанийн засаглалын кодекст заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дотоод хяналтын бүтэц, зохион байгуулалтыг шийдвэрлэж, түүний ажиллах журмыг баталж мөрдүүлнэ.

11.7. Компани нь Аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, здийн засгийн үйл ажиллагаанд бурэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилж ажиллуулна.

11.8. Төлөөлөн удирдах зөвлөл аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлслний хэмжэг заана.

11.9. Санхүү, здийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь эзлжит ба эзлжит бус байна. Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэгт заасны дагуу аудитын шалгалт хийнэ.

11.10. Дараах этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:



11.10.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлслний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

11.10.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

11.10.3. компанийт аудитиас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

11.11. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд эзлжит шалгалт хийнэ.

11.12. Компанийн бичиг баримтыг хадгалах Компани нь хяналт шалгалт, плавлагаа, түүх, архивын зорилгоор баримт бичгийг холбогдох хуульд зааснаар хадгалана.



**АРВАН ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,
ТАТАН БУУЛГАХ**

12.1. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

12.2. Мөн хуульд заасан тохиолдолд шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

12.3. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэн.

12.4. Дор дурьдсан үндэслэлээр шүүх компанийг татан буулгана.

12.4.1. компани дамжуулсан;

12.4.2. нэг ч гишүүн үлдээгүй;

12.4.3. хуульд заасан бусад үндэслэл.

12.4. Татан буулгах шийдвэр гаргах үед компани нь ямар нэгэн өргүй бол компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлэхгүй байж болно.

12.5. Бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буутганд тооцно.

**АРВАН ГУРАВ. ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,
ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

13.1. Компанийн энхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн нариуултыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална.

13.2. Энхүү дүрэм нь Улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилнэ.

“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИ





СИЛИКАТ ХХ

Д/р. 100, Улан-Батор, Монголия

№ 22/2010

Загустай 3 - 2010 г.

САНКТУАРИЙ ЗООВЛЮДНЫХ ЖИВОТНЫХ

Художник: А. Сарычев

Монголийн наамжийн улсын цэсийн Удзүүдлийн төхөөрөмжийн
Улсын шийдвэр төгрөг 2010 оны 12 сарын 25-нд яаралсан байгаа. Бие у
бийцаасын СЭХ нь манадын дундажийн эзэнтүүдийг хийгүүдийн улс
цэсийн Төхөөрөмжийн түүхэдэд жарчилж ирвэнийг агуулж түүх та буюн
цэвэртэй цэвэртэй улсын цэсийн төхөөрөмжийг зорлогүй бөйн.

Ихэвч та буюн барийн шинэгийн түүхийн шүүхийн улсын цэсийн
аасанайг күтээн авсан уу.

ХИДЭЛГЭСЭН:
ГҮҮШЧИЙН НАМЖИРД

А. Сарычев
Ц. Сарычев

Print Date: 09/07/2010 09:00:00 AM



Хурлын протокол

2011.05.01

№

Дархан-Уул аймаг

"Силикат" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал компанийн байранд 2011 оны 05 сарын 1-ний өдөр 15 цагт 99,36 % ирцтэйгээр хурал эхлэв. Хуралд 7 хувь нийлүүлэгчид оролцов.

д/д	Хувь нийлүүлэгчдийн нэр	Эзэмших хувьцааны тоо	Эзэмших хувь хэмжээ	Бусад
1	Ц.Содбигэл	42 438	24.94	
2	Ц.Сэргэлэн	2 552	1.5	
3	Н.Цогцлон	12 760	7.5	
4	С.Золбоотегс	36 947	21.72	
5	С.Оджаргал	32 199	18.93	Итгэмжлэлээр
6	В.Мөнхтуяа	20 415	12.00	
7	Д.Энхболд	21 726	12.77	
	Нийт	169 037	99.36	

Хурлаар хэлэлцэх асуудал

- ✓ Нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой асуудлууд дээр ярилцаж, шийдвэр гаргах
- ✓ Бусад

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ж.Ганболд хурлыг нээв: Та бүхэнд хуралд хүрэцэн ирсэнд талархаж байгаагаа илрэхийлээд, хурал нээснийг мэдэгдээ. Энэ хурлаар бид нэмэлт хувьцаа гаргахдаа хувьцааг хэрхэн хуваах, нэрлэсэн үнийг хэдээр, зах зээлд санал болгох доод үнийг хэдээр тогтоох вэ гэдэг асуудлуудыг танилцуулж шийдвэр гаргахаар цуглаад байна.

Ц.Содбигэл: Нэгж хувьцааг 177 ширхэгт хуваахаар төлөвлөсөн байгаа. Хувьцаа хуваагдсаны дараа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн унс бүхий 30 112 302 ширхэг энгийн хувьцаатай байх юм. Компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 ширхэг хувьцааг зах зээлд зах зээлд 225 төгрөгөөр санал болгон хөрөнгө татан төвлөрүүлж, төвлөрсөн хөрөнгөөрөө ер төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, шохой үйлдвэрлэлийн хучин чадал, ашигт ажиллагааг нэмэгдүүлж ажиллана. Энэ тал дээр та бүхнийг дэмжиж ажиллах байх гэдэгт найдаж байна.


Ц.Сэргэлэн: Шаардлагатай байгаа 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татахад ийм хувилбар нь илүү дөхөмтэй байгаа гэж үзэж байгаа бол би дэмжиж байна.

Н.Цогцлон: Дэмжиж байна.

Д.Энхболд: Санал нэгтэй байна.

В.Мөнхтуяа: Саналыг зөвшөөрч байна

Ж.Ганболд: Өнөөдрийн хуралд идэвхитэй оролцож, санал нэгтэй байгаад та бүхэнд талархаж байна.



Хурлаас:

- Компани нь өөрийн хувьцааны зах зээл дэх эргэлтийг идэвхижүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зорилгоор нэгж хувьцааг 177 ширхэгт хуваах. Хувьцаа хуваагдсаны дараа компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрласэн унс бүхий 30 112 302 (гучин сая нэг зуун арван хоёр гурван зуун хоёр) ширхэг энгийн хувьцаатай байх.
- Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, ер төлбөрийн асуудлыг шийдвэрлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 35%-тай тэнцэх 16 222 300 (арван зургаан сая хоёр зуун хорин хоёр гурван зуу) ширхэг хувьцааг зах зээлд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлэх
- Нэмж гаргаж буй хувьцааг зах зээлд санал болго доод үнийг 225 төгрөгөөр тогтоох.
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэчилсэн найруулга бүхий дүрмийг батлах зэрэг асуудлууд дээр санал хурааж, хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн санаалаар дэмжиж баталлаа. Асуудлуудыг бүрэн хэлэлцэж дууссан тул хурлыг 17 цагт өндөрлөв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

Ц.Содбилэг

Ц.Сэргэлэн


Н.Цогцлон

В.Менхтуяа

Ц.Золбоотэгс

Д.Энхболд

Хурлын протокол хөтөлсөн Ш.Батмэнх





МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

г “Силикат” ХК-ийн хувьцааг хуваах, нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 52.2 дахь заалт, “Силикат” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2011 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 01, 02, 03 дугаар тогтоолууд, тус компаниас 2011 оны 5 дугаар 02-ны өдөр ирүүлсэн У19/11 тоот “Хүснэгт гаргах тухай” албан бичгээр гаргасан шинэчилсэн хүснэгтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Силикат” ХК-ийн ёмис гаргасан 170,126 /нэг зуун далан мянга нэг зуун хорин зургаан/ ширхэг хувьцааны нэгж хувьцаа бүрийг тус компанийн 2010 оны жилийн эцсийн санхүүгийн балансад үндэслэн тооцсон нэгж хувьцааны дансны үнз болох 17,765 /арван долоон мянга долоон зуун жаран тав/ төгрөгөд үндэслэн нэгж хувьцааг тус бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 177 /нэг зуун далан долоон/ ширхэг хувьцаанд хувааж, компанийн нийт гаргасан хувьцааны тоог 30,112,302 /гучин сая нэг зуун арван хоёр гурван зуун хоёр/ ширхэг болгон хөрүүлж, энхүү тогтоолын хавсралтад заасан жагсаалтын дагуу хувьцаа эзэмшигчдэд эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын I-д заасны дагуу тус компанийн үнэт цасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Силикат” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй тус бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 16,222,300 /арван зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга гурван зуун/ ширхэг хувьцааг үнэт цасны бүртгэлд нэмж бүртгэн тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 46,334,602 /дечин зургаан сая гурван зуун гучин дөрвөн мянга зургаан зуун хоёр/ ширхэг хувьцаа байхаар үнэт цасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгож, хөрөнгийн

биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд нэмж гаргах гэх буй зарласан хувьцааг компанийн зээмшилд бүртгэхийг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 3-т заасан 16,222,300 /арван зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга гурван зуун/ ширхэг хувьцааг унэт цаасны танилцуулгад заасны дагуу анхдагч зах зээлд нэгж хувьцааг 225 /хоёр зуун хорин тав/ төгрөгөөс доошгүй үнээр захиалгын бүртгэл хийх аргаар санал болгохыг зөвшөөрч, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай 3,650,000,000 /турван тэрбум зургаан зуун тавин сая/ төгрөгийг бүрэн төвлөрүүлж чадсан нөхцөлд унэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажилллагааг амжилттай болсонд тооцоохор тогтсугай.

5. Энэ тогтоолын 3-т заасан 16,222,300 /арван зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга гурван зуун/ ширхэг хувьцааны 50 хувьтай тэнцэх хэмжээний 8,111,150 /найман сая нэг зуун арван нэг, нэг зуун тавы/ ширхэг хувьцааг андерсрайтер болох “БиДиСек” ХК-д /Д.Даянбилгүүн/ нийтэд худалдахаар тогтоосон үнээр худалдан авч болохыг зөвшөөрсүгэй.

6. “Силикат” ХК-ийн унэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 3-т заасан хувьцааг нийтэд санал болгон унэт цаасны анхдагч зах зээлд гаргасан өдрөөр тасалбар болгон “Силикат” ХК-ийн том хувьцаа зээмшигчид болох иргэн Цэрэннадмын Содбилг /УХ68011611/, Доржийн Энхболд /ЧМ66082773/, Содбильзгийн Золбоотгс /УХ94070722/, Содбильзгийн Оджаргал /УЦ06291436/, Нямдашийн Цогцлон /ЧГ61111910/, Володягийн Мөнхтуяа /ХЗ80102569/ нарын өмчлөл дэх “Силикат” ХК-ийн энгийн хувьцаануудыг тус бүр нэг жилийн хугацаагаар тусгаарлахыг “Унэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

8. Тус компанийн гаргасан хувьцааг хуваах, нэмж унэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Силикат” ХК /Ц.Содбильзг/, “БиДиСек” ХК-д /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай:

1/ тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан хувьцаа хуваах болон нэмж унэт цаас гаргах шийдвэртэй холбогдуулж нийт хувьцаа зээмшигчдэд хувьцаагаа компанийд эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг ажлын 60 хоногийн дотор зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнаж, “Монголын хөрөнгийн бирж” болон олон нийтэд мэдээлэх;

2/ энэ тогтоолын 3-т заасан 16,222,300 /арван зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга түрвэн зуу/ ширхэг хувьцаа гаргах тухай үнэт цаасны танилцуултыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн үнэ төлбөргүйгээр олон нийтэд нийтлэг мэдээлэл хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үргээ чанд биелүүлж ажиллах;

3/ үнэт цаасны танилцуулгад заасан хубаарийн дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулж, захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны програмд тулгуурлан авч, захиалга хааснаас хойш ажлын 3 хоногийн дотор уг үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах үнийг хэрхэн тогтоосон тухай мэдээллийг тус Хороонд ирүүлж анхдагч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл авах;

4/ үнэт цаасыг анхдагч зах зээлийн арилжааны тайлланг уг арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан тус Хороонд ирүүлэх, тайланд тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулхтай холбогдсон баримтыг хавсарган ирүүлэх.

9. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд үнэт цаас худалсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Силикат” ХК-ийн дансанд байршсан мөнгөн хөрөнгийн андеррайтерээс бусад иргэн, хуулийн этгээдээс оруулсан хөрөнгийг тус компани хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах болон удирдлагын бүтцэд өөрчлөлт орох талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэл хугацаанд тусгаарлахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулат/-д үүрэг болгосугай.

10. Улсын бүртгэлийн өрөнхий газарт 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар//Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.



Санхүүгийн зохицуулах хорооны
2011 оны 130 дугаар тогтоолын хавсралт

/2011/05/06-ны одрийн байдлаар/

	Овог нэр	Регистр	Одоо эзэмшиж байгаа ширхэг	Хувасны дараа эзэмших ширхэг
1	Ц.Содбилэг	УХ68011611	42,438	7,511,526
2	Д.Энхболд	ЧМ66082773	21,726	3,845,502
3	С.Золбоотөгс	УХ94070722	36,947	6,539,619
4	С.Оджаргал	ҮИ06291436	32,199	5,699,223
5	Н.Цогцлон	ЧГ61111910	12,760	2,258,520
6	В.Менхтуяа	Х380102569	20,415	3,613,455
7	Ц.Сэргэлэн	ХГ60012671	2,552	451,704
8	Ц.Цэрмаа	ТВ38070185	212	37,524
9	Баянмэн	ТА65082377	175	30,975
10	Дэмбэрэл	ТА18070186	175	30,975
11	Б.Бурмаа	ТЕ57111606	166	29,382
12	Долгормаа	ТА71042161	116	20,532
13	Ч.Цэвэнжав	МЭ63123001	84	14,868
14	Бидисек	РЕ-2052482	69	12,213
15	Ү. Хашбаатар	ДЮ65052616	30	5,310
16	Ж.Оюунцэцэг	СЮ62021706	12	2,124
17	Д.Даянбилгүүн	ХП76061036	11	1,947
18	Л.Гантуяа	ТА59072066	10	1,770
19	Чойжилсүрэн	ФА37031814	7	1,239
20	Алтансүх	ПЭ81,31711	4	708
21	Эмитиэф	РЕ-5153794	4	708

22	Цэдэв	ФА38011319	3	531
23	Эрдэнэцэцэг	БС63041802	2	354
24	С.Оюундэлгэр	ХВ55101361	2	354
25	Б.Самдан	ШБ42082418	2	354
26	Д.Лхажид	ХИ31091514	2	354
27	Энхтунгалаг	ХВ64061260	1	177
28	Сэрэхүү	АБ20111634	1	177
29	Очирбат	ХК100423420	1	177
			170,126	30,112,302

-000000-